

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-2

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 3-8

---

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, шаардлагатай бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/ 3-8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны  
06 дугаар сарын 04-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 16 минутад Төрийн ордны “Их Засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Мөнхбат, Т.Мөнхсайхан;  
Тасалсан: Ч.Номин, Б.Пунсалмаа.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, шаардлагатай бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Инновацын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Мөнхбат, мөн газрын ахлах шинжээч М.Солонго, Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтсийн шинжээч Б.Солонго нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ байлцав.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Инновацын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Мөнхбат танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Галбадрах нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Золжаргал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Инновацын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Мөнхбат нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Ж.Золжаргал:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

|             |   |
|-------------|---|
| Зөвшөөрсөн: | 5 |
| Татгалзсан: | 2 |
| Бүгд:       | 7 |

71.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 25 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 41 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
14 цаг 16 минут.

### **ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ж.Золжаргал:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, 54,5 хувиар ирц бүрдсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаан нээгдсэнийг мэдэгдье. Хэлэлцэх асуудлаа танилцуулахаас өмнө хуралдааны ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар ирсэн байна, Э.Батшугар ирсэн байна, А.Ганбаатар ирсэн байна, Ж.Золжаргал ирсэн байна, Ч.Ундрам ирсэн байна, С.Цэнгүүн нарын Улсын Их Хурлын гишүүд ирсэн байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах тухай байгаа. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих, дагалдах эрх зүйн орчныг сайжруулах ийм агуулгатай. Тэгээд хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орьё. Хэлэлцэх асуудал 1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, шаардлагатай бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас товч мэдээлэл хийнэ. Урьд нь бид энэ сэдвээр ярилцсан байгаа. Тийм. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг хүлээсэн хүмүүс мэдээллийн технологи, IT салбарын start-up-ууд залуучууд маш их бий. Хуулиа хэрэгжүүлэхэд дагах журмуудыг бид нэлээн удаан хүлээлээ. Журмаар зөвхөн зохицуулж барахгүй юм байна, бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт шаардлагатай байна гэдэг дүгнэлтийг салбарын яамнаас гаргасан. Ямар өөрчлөлтүүд оруулж болох вэ гэдэг талаар 4 дүгээр сард нэмэлт, өөрчлөлтийн төслийн эхний ээлжид боловсруулаад танилцуулна гэсэн. Энэ ажил маань хийгдсэнгүй, 6 сар болж байгаа. Тийм болохоор ер нь Байнгын хороон дээр ажлын хэсэг гаргаад, давхар шахаж шаардаж явъя. Шаардлагатай бол хуулийн төсөл дээр бид ажиллая гэсэн агуулгаар өнөөдөр болж байна. Инновац, Инновацийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхбат дарга товч мэдээлэл хийнэ үү. Бүрэн бүр агуулга үндэслэл гэж яах бол шаардлага байхгүй байх, ерөнхийдөө мэдэж байгаа учраас. Тэгээд тохиолдож байгаа асуудлууд, ямар өөрчлөлтүүд шаардлагатай байгаа, тэгээд өнгөрсөн хугацаанд ямархуу, ямар шалтгаанаар энэ маань нэлээн их цаг аваад явчлав? Энэ талаар голдуу анхаарч хэлэхийг хүсье. Баярлалаа. 6 дугаар микрофон нээж өгье.

**П.Мөнхбат:** Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Инновацийн бодлого, зохицуулалтын газрын дарга Мөнхбат. Байнгын хорооны даргын сая хэлсэнчлэн энэхүү хууль өнгөрсөн оны 6 сарын 5-ны өдөр батлагдсан. Яг нэг жилийнхээ ойн дээр ингээд хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн хуулийн хэрэгжилтийн явцын

талаар танилцуулга хийе товч байдлаар. Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 7 дагалдах журмыг ийм батлах төлөвлөгөөтэй байгаа. Яамны зүгээс өнгөрсөн оны 3 дугаар улирлаас эхлэн энэ хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үндэсний зөвлөлийг байгуулсан байгаа. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг ЗГ-ын 2024 оны 97 дугаар тогтоолоор байгуулсан нэгдүгээрх нь. Хоёрдугаарх нь Үндэсний зөвлөл байгуулагдмагцаа мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын хэсэг ажлаа, төслийн стратеги төслийг боловсруулан 2025 оны эхний улиралд багтаан танилцуулсан бөгөөд 25 оны Үндэсний зөвлөлийн 25 оны 03 дугаар тогтоолоор Стратеги, төлөвлөгөөгөө баталсан байгаа.

3 дугаар, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 3 дугаар батлах зүйл энэ Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлах ажил байсан. Энэхүү ажил ЗГ-ын 24 оны 141 дүгээр тогтоолоор мөн боловсруулж, батлуулсан байгаа. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 4 дүгээр батлах асуудал бол Дэвшилтэт технологийн жагсаалтыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага саналыг үндэслэн батлах байгаа. Энэхүү ажил бол дэвшилтэт технологийн нэр томъёоны тайлбар боловсруулах, мөн дэвшилтэт технологийн талаарх судалгаа хийх ажлын хэсгийн үр дүнг үндэслэж, боловсруулахаар яамны, яаман дээр ажлын хэсэг байгуулагдан одоогоор ажиллаж байгаа. 5 дугаарх нь Мэдээлэл, технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам болон Татварын болон татварын бус дэмжлэгийг үзүүлэх журам гэсэн энэ 2 журмыг яамны, яаман дээр Үндэсний зөвлөлөөс 2025 оны 4 сарын 4-ний өдөр Үндэсний зөвлөл энэ 2 журмын төслийг боловсруулж, батлуулж яам руу хүргүүлсэн. Яам холбогдох саналуудыг ЗГ-ын яам, агентлаг, яамнуудаас саналыг нь аваад ЗГХЭГ луу хэлэлцүүлэхээр шилжүүлсэн байгаа. Тэгээд Хэрэг эрхлэх дээрээс өгч байгаа мэдээллээр ирэх долоо хоногийн ЗГ-ын хуралдаанаар энэхүү журмын батлах ажил хийгдэнэ гэж тооцогдож байгаа.

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 6 дугаар, 7 дугаарх нь хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийг дэвшилтэт технологид суурилсан сэндбокс байгуулах холбогдох журам батлах гэж байгаа. Энэ журмын төслийг яаман дээр эхний байдлаар боловсруулсан. Холбогдох судалгаа шинжилгээний ажил хийгдэж дууссан, журмын төсөл боловсруулчихсан байгаа. Энийг цааш нь яамнууд руу явуулж, визэнд гаргаж, санал зөвлөмж авах гэхэд тодорхой бэрхшээлүүд байгаа. Тухайлбал тус хууль дээр тусгагдсан зохицуулалт зөвхөн сэндбокс орчныг байгуулах тухай 1 заалт байгаа. Өөрөөр хэлбэл энэ сэндбоксыг цааш нь тогтвортой авч явах санхүүгийн болон дэд бүтцийн зохицуулалт нь тодорхой бус байдал байгаа учраас энэ бол журмын төслийг дээд байгууллагуудаас тодорхой чиглэл авсны дагуу нарийвчилж боловсруулна гэсэн төлөвлөгөөтэйгөөр ямар ч байсан эхний журмын төслийг боловсруулчихсан ингээд хүлээгдээд байж байгаа.

Ингээд энэ хуулийн хэрэгжилтийг хангахаар, хангуулах холбогдох журмын 7 журмыг батлах ёстойгоос одоогоор 5-ыг нь баталчихсан. 2-ыг нь журмын төсөл эхний шатны судалгааны ажлууд хийгдчихсэн ингээд хүлээгдэж байна. Болчихлоо.

**Ж.Золжаргал:** Мэдээлэлтэй холбоотой асуулт, тодруулга асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүн байхгүй байна. Уучлаарай, Анар гишүүн асуулт асууна.

**Ч.Анар:** Энэ сонгуулийн наана мэдээллийн технологийг дэмжинэ гээд аягүй олон мөрийн хөтөлбөр орж ирээд гоё, гоё заалт орж ирээд, тэгээд ерөөсөө хэрэгжихгүй байгаа. Батшугар гишүүний энэ санаачлан байгуулсан энэ Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих, түүнийг дагах хуулиуд дээр олон заалт орсон. Жишээ нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын хуулийн 22.5.4 билүү, 22.5.4 гарааны шинэ компаниудыг 5 жилийн дотор татвараас 100 хувь чөлөөлнө гэж орж ирсэн. Тэгээд одоо болтол хэрэгждэггүй. Тэгээд Сангийн яам, Цахимын яамнаас асуухаар журам боловсруулах дутуу байгаа гээд байдаг. Тэгээд энэ одоо болтол ингээд журмаа яасан удаан боловсруулагддаг юм бэ? Тэгээд энэ Сангийн яамныханд хэлэхэд бас сонирхолгүй байгаа юм шиг байна лээ. Тэгээд энэ компаниуд чинь бойжиж байж, Монгол чинь өөрөө залуучууд чинь татварын дарамт доор биш, бусад улсууд шиг татварын санхүүгийн дэмжлэг өгөх байтугай зүгээр ажиллаж эхлээгүй байхад нь л татвараараа дарамталчихдаг асуудлаа шийднэ гэж гоё яриад, гоё хууль батлуулчихаад, тэгээд хэрэгжүүлдэггүй. Тэгээд эндээс чинь нэг их тийм улсын төсөвт бүрдээд байхаар тийм сүртэй татвар байхгүй шүү дээ. Энэ асуудал байна.

Дахиад энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 15.1.19 дээр оруулсан гарааны компаниудын хийсэн хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлнө гэдэг заалтыг Сангийн яам хууль дээр оруулсан заалтыг яагаад хасчхаж байгаа юм бэ? Энэ асуудлыг ер нь Цахим яам яагаад хойноос нь хөөцөлдөхгүй, үйл ажиллагаа хийхгүй, та хэд салбараа ерөөсөө, ярихдаа бол ийм хууль баталчихсан, бид технологийн компани, start up, залуучууд, гарааны бизнесийг дэмжиж байгаа гэсэн мөртөө үг, үйлдэл дээрээ яг юу ч байхгүй байгаад байгаа шүү дээ. Энийг яах юм бэ?

**Ж.Золжаргал:** 6 номер хариулъя. Яг ямар хүндрэл тулгараад, яагаад ингээд жил болчихсон бэ? 6 дугаар микрофон нээж өгнө үү.

**П.Мөнхбат:** Анар гишүүний асуултад хариулъя. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх тухай зохицуулалт бол 12-ын, 13.2 болон 13.3 дээр заагдсан байдаг. Энэ зохицуулалтыг хийх зорилгоор журмын төслийг боловсруулсан. Холбогдох яамнуудаас ялангуяа Сангийн яамнаас тайлбар, тодруулгуудыг авсан. Тэгэхээр Сангийн яамнаас өгч байгаа байр суурь бол татварын дэмжлэгийг энэ хууль болон түүнийг дагаж гарч байгаа журмаар зохицуулахгүй. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх тухай асуудлыг Сангийн яамны 292 дугаар тогтоол сайдын тогтоолоор зохицуулдаг юм. Тийм учраас энэ хуулийг дагаж гарч байгаа татварын дэмжлэгтэй холбоотой зохицуулалтыг Сангийн сайдын 292 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу зохицуулагдана гэсэн тайлбар өгөөд, бидний боловсруулж Засгийн газар луу өргөн барьсан журмаас бол хасуулсан ийм байр суурьтай байгаа.

**Ж.Золжаргал:** Анар гишүүн тодруулна.

**Ч.Анар:** Тэгээд энэ хуулийнхаа харин, би дахиад асуугаад байна шүү дээ дахиад. Энэ хуулиа аягүй гоё PR хийдэг яам нь. Тэгээд эргээгээд энэ журмаа батлуулах дээрээ Сангийн яамтайгаа ерөөсөө хөөцөлдөхгүй байна лээ шүү дээ. Ноднин төсвийн тодотголын үеэр, төсвийн үеэр энэ асуудлуудыг чинь зөндөө л Сангийн яамтай ярьсан. Тэгээд танайхаас хүн хөөцөлдөж явахгүй байгаа юм байна лээ шүү дээ. Нийт 7 журам гарах шаардлагатай байгаа юм байна лээ. Тэгээд энэ асуудлаа хөөцөлдөж яваагүй байж Сангийн яам 292 дээр нэг хасчихсан гээд байгаа юм. Энэ чинь очоод хөөцөлдөөд, Сангийн яамандаа танилцуулаад л долоо хоногийн ажил байлгүй дээ их үсрээд. Энэ чинь хууль биш журам шүү дээ. Тэгээд

яг ингээд нөхцөл байдлаа сайн мэдэж л байгаа. Тэгээд яг үр дүнд ерөөсөө хүрэхгүй ингээд манайх биш, Сангийн яам гээд байдаг. Яг эцсийн эцэстээ танай яамны харьяа журам, хуулийг хамгийн гол хийх ёстой ажлаа хойноос нь яагаад хөөцөлдөхгүй байгаа юм бэ гэж асуугаад байгаа юм?

**Ж.Золжаргал:** 6 номер.

**П.Мөнхбат:** Энэхүү журмыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн үндэсний зөвлөлөөс ажлын хэсгийг 12 сарын, өнгөрсөн оны 12 сард байгуулаад, тэр ажлын хэсгийн бүрэлдэхүүн бол яаманд 4 сарын 4-ний өдөр эцэслэн боловсруулсан журмын төслийг танилцуулсан. Яам улмаар энэ журмын төслийг хүлээж аваад, холбогдох санал шүүмж, зөвлөмжийг нэгтгээд, Засгийн газар луу өргөн барьсан байгаа л даа. Дээд байгууллагаас журмын төсөл дээр ажиллаад, 4 сарын 4-ний өдрөөр шилжүүлсэн байгаа.

**Ж.Золжаргал:** Асуулт асуулаа. Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Асуулт асууя? Галбадрах гишүүний микрофон.

**Ж.Галбадрах:** Би энэ Байнгын хороонд ер нь орж ирсэн маань боловсролын салбарт инновац, цахим технологийг нэвтрүүлэх чиглэлээр ажиллах, тэнд санал оруулах гэсэн энэ гол зорилгоор орж ирсэн. Тэгээд өнөөдрийг хүртэл бидний хэлэлцээд байгаа асуудал дотор маань боловсролын салбарын асуудал тийм их том байр суурь эзлэхгүй, орж ирж байгаа асуудлууд нь дандаа төрийн байгууллагууд дээр цахимжуулах, ИМонголиагаас эхлээд, цахим сонгууль явуулах энэ тэр ч гэдэг юм уу ийм макро асуудлууд ингээд яригдаж орж ирээд байгаа.

Тэгээд бидний хувьд энэ Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль гээд яригдаж байгаа бол энэ сургуулийн цахим орчин, сургуулийн мэдээлэл технологийн сургуульд зориулсан, боловсролд зориулсан энэ цахим технологийн үйлдвэрлэл энэ тэрийг хэрхэн тусдаг юм бэ? Сургууль гэдэг маань маш олон сурагчид, оюутнууд байна боловсролын салбарт маань. Ялангуяа дээд боловсрол гээд ороод ирвэл ийм байна. Ахлах анги гэж байж байна. Багш нар гэж байна. Багшийн хөдөлмөр, багшийн ажлын байранд энэ цахимжиж ирж байгаа, тэр бүртгэлүүд янз бүрийн бүртгэлүүд маш их олон зүйлүүд ингээд орж ирдэг. Тэгээд энэ бүгдийг их зохистой харилцаанд очихгүй бол одоо ийм мэдээллүүд авъя, ийм судалгаа авъя гэдэг юм нь цахимаар орж ирж байна. Тэр байтугай цахимаараа ирцээ авна гээд л энэ асуудлууд ингээд орж ирээд л, eschool ч гэдэг юм уу ингээд янз бүрийн энэ нэгдсэн нэг тийм бодлогогүйгээр орж ирээд байгаа учраас маш олон энэ цахим юманд багш нэлээн дарагдаж байгаа. Тэгэхдээ цахимжаад ирвэл тэр ажил хөнгөвчилнө, хөдөлмөр нь хөнгөвчлөгдөнө гэдгийг ойлгож байгаа. Тэгэхээр энэ талаар ер нь хэр энэ хуульд туссан байдаг юм бэ?

Ялангуяа бид багш их дутагдалтай байж байгаа үед багшийн туслах ч гэдэг юм уу хиймэл оюун ухаан ашиглаад, энэ виртуал багшийн систем гээд орж байна, сурах бичиг байж байна. Сурах бичгүүдийг зүгээр нэг ийм цаасан сурах биш сурах бичиг биш, дижитал болгох, физик, химийн сурах бичгүүд байж байна, бид энэ лабораторийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй байж байна. Тэгвэл өнөөдөр байж байгаа сурах бичиг дээрх тэр энерги хадгалагдах хууль ч байдаг юм уу, импульс хадгалагдах хууль гээд заалаа гэхэд тэрний тэр demonstration буюу тэрний туршилтуудыг хийж байгаа юмнууд дэлхийн олон оронд ингээд хийгдээд, гадаадад хийгдээд ирчихсэн гоё, гоё туршилтуудыг бид видео хэлбэрээр ингээд энэ онлайнд



тавигдчихсан байж байгаа шүү дээ. Тэрийг сурах бичиг дээр нь оруулж ирээд, тэрийг гаргаад явах ч гэдэг юм уу ийм чиглэлийн цахим технологийн шилжилтүүд, үйлдвэрлэлүүд боловсролын салбарт их хэрэгтэй байгаа юм. Тэгэхээр энэ тэр тухай энэ хуульд маань хэр их тусгадаг юм бэ? Би энэ Байнгын хороондоо орж ирснээр ерөөсөө л яг боловсролын хүлээгээд байх биш, боловсролын салбарт цахим технологи, цахим технологийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн технологиуд хэрхэн орж ирж байгаа талаар ингээд асууж явна гэж бодож байна. Энэ тал дээр энэ хуультай холбогдуулаад хариулт авъя.

**Ж.Золжаргал:** 6 номер, Мэдээллийн технологийн хууль болон ер нь боловсролын цахим шилжилтийн талаар нэмэлт мэдээлэл өгвөл сайн байна. 6 номер нээж өгье.

**П.Мөнхбат:** Гишүүний асуултад хариулъя. Энэхүү хууль бол яг мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарыг дэмжих тухай ийм хууль байгаа. Тэгэхээр тухайн эдийн засгийн үйл ажиллагааны салбараас үл хамаараад аливаа мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хэрхэн дэмжих вэ, тэднүүсийн тэдгээрийн татварын болон татварын бус дэмжлэгийг яаж олгох вэ тухай л зорилгоор боловсруулагдаж, батлагдсан ийм хууль, эрх зүйн бичиг баримт байгаа. Энийг боловсролын салбарт ажиллаж байгаа боловсролын салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр зорьж байгаа Мэдээлэл технологийн үйлдвэрлэл эрхлэгчид, гарааны бизнес эрхлэгч нарт бүрэн нээлттэй, чөлөөтэй. Өөрөөр хэлбэл тухайн программ хангамж хөгжүүлэгч аж ахуйн нэгж, гарааны бизнес эрхлэгчид маань хуулийн 13.3-д заасан энэ татварын бус дэмжлэгийг авах зорилгоор хиймэл оюунд суурилсан таны хэлсэн сая багшийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ эд нар хийсэн тохиолдолд 60 хүртэлх хувийнхаа өртгийг дэмжлэг авах ийм зохицуулалттай байгаа. Тэгээд тухайлсан нэг салбар дээр энэ зохицуулалт тусгагдаагүй ийм эрх зүйн баримт бичиг байгаа. Хариулт дууслаа.

**Ж.Золжаргал:** Галбадрах гишүүний микрофон.

**Ж.Галбадрах:** Харин тийм л дээ. Тэгээд багшийн бүтээмжийг дээшлүүлэх, тэгээд боловсролын салбар луу нь яах вэ тухайн нэг салбарын хэрэглэгч нарт зориулаагүй гэж байгаа боловч үйлдвэрлэгч нарыг нэг олноор боловсролын салбарт гарч ирэх, ялангуяа сургууль дээр цахим зөв хэрэглээ гэдэг асуудал их яригддаг. Бид сургууль дээр хүүхдүүд суугаад, гар утсаа хэрэглээд аппликэйшн хэрэглэж байгаа. Мэдлээ.мн гэдэг юм уу энэ хичээлүүддээ ороод үзэх нэрээр зүгээр л цахим орчинд ингээд орчихсон явж байгаа. Тэгвэл энэ чиглэлээр нь энэ хуульд тэр сургуулийн орчин дахь бид facebook-г хязгаарлах, тодорхой цаг хязгаарлах, бусад youtube үзэх тал дээр нь хязгаарлах ч гэдэг юм уу, яг нэг энэ салбарын, тэгээд цэцэрлэгийн нас, бага анги, дунд анги, ахлах анги, тэгээд энэ оюутан болж ирэх энэ чиглэл рүү нь зориулсан ийм үйлдвэрлэлүүдийг.../минут дуусав/

**Ж.Золжаргал:** 6 дээр нэмж хэлэх үү, болсон уу? Бид саяхан нөгөө яамнаас мэдээлэл бэлдүүлж авсан. Нийтдээ 13 мянга гаруй цахим системүүд бүртгэлтэй төрийн байгууллагуудаар байгаа гэж байгаа. Тэндээсээ 3 мянга гаруй нь боловсролын салбарт нэлээн хамгийн том дүнгүүдийнх нь нэг нь. Тэгэхээр ер нь Галбадрах гишүүн болон бусад гишүүдтэйгээ цагаа ярьж байгаад боловсролын цахим шилжилтийн талаар мэдээлэл сонсох хурал зохион байгуулъя гэж бодож байна. Тэгээд түүнийхээ араас хэдүүлээ ямар хуулийн төсөл, юун дээр ажиллах вэ гэдгээ ярилцъя. Мэдээлэл өгсөнд баярлалаа.



Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хуулиа ажиллуулахгүй бол их гоё хууль гарсан. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл хийж байгаа залуучууд маань одоо дэлхий ч нээлттэй болчихсон учраас гадагшаа явах үзэгдэл нэлээн гарч байгаа. Тэгээд энэ Төв Азийн улсууд, Европын улсууд, Өмнөд Азийн улсууд очоод амьдрахад өртөг нь бага, IT хөгжүүлэхэд татвар нь байхгүй, улсаас нь байр савыг нь өгчихдөг, борлуулалт дээр нь дэмждэг ийм бодлогууд олон улс хэрэгжүүлж байгаа учраас яагаад энд байх хэрэгтэй юм бэ гэдэг асуултуудыг тавиад байна. Тэгэхээр энэ бол их харамсалтай зүйл. Тийм болохоор аль, аль талаасаа богино хугацаанд энэ хуулиа ажилладаг болгоё. Энэ зорилгоор Байнгын хороон дээр ажлын хэсэг гаргах нь зөв юм гэсэн ийм саналыг гишүүд гаргасан. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулна. Тогтоолын төслийг, болчихсон шүү. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг, хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, шаардлагатай бол хуульд өөрчлөлт оруулах төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ц.Мөнхбат, Л.Соронзонболд, Ж.Галбадрах.

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн хүмүүс татан оролцуулах, мэдээлэл судалгаа гаргуулан дүн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Энэ тогтоолын биелэлтийг 2025 оны Улсын Их Хурлын намрын чуулганд багтаан Инновац, цахим бодлогын байнгын хороонд танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагчид даалгасугай гэсэн агуулгатай. Ингээд 4 гишүүнтэй. Ажлын хэсгийн гишүүнд нэмэгдэж орох болон ажлын хэсгийг ахлах саналтай гишүүн байвал саналаа өгнө үү? Асуулт асууж, үг хэлэх. Ингээд ажлын хэсэг дээр, тогтоолтой холбоотой асуулт асуух, үг хэлэх хүн байна уу? Асуулт асууж, үг хэлэх хүн байхгүй байна. Ингээд ажлын хэсгийг Ж.Золжаргал ахлаад, гишүүдээр нь Анар, Мөнхбат, Соронзонболд, Галбадрах нарын Улсын Их Хурлын гишүүд ажиллахаар зөвшилцлөө. Ахиж унших шаардлагагүй байх.

Тогтоолын төслийг дэмжинэ гэдэг агуулгаар санал хураалт явуулна. Санал хураалтад бэлдэж, хуруугаа уншуулна уу. Бэлэн болсон байна. Тогтоолын төслийг дэмжих томьёоллоор санал хураалт. Санал хураалт 71,4 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ. Байнгын хорооны тогтоол Ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцэж, баталлаа.

14.41 цаг

Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

